



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 4/39

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын ой, хөрсний доройтол, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, сайжруулах, хамгаалах, тэмцэх зорилгоор “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ” хийлгэх ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд: Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)
Н.Түвшин (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтыг боловсруулан 3-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжээс үнийн санал авч нийлүүлэгчийг сонгон шалгаруулахыг Ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

С.АМГАЛАН

